# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 12 өдөр Дугаар А/24

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хандивласан 63,309,400.0 (жаран гурван сая гурван зуун есөн мянга дөрвөн зуу) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв (И.Батзаяа)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв (И.Батзаяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

1425030054

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/14 дугаар тушаалын хавсралт

# Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв

| № | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Үзүүлэлт | Үйлдвэрлэсэн он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэх анхны | | Хандивлагч байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Нэгжийн үнэ | Нийт үнэ | нэр | Эх үүсвэр |
| 1 | Сервер | Dell R940 | CPU 4*8160 Memory 8*32G/Storage /4*1.92T | 2024 | шинэ | ш | 1 | 63,309,400.00 | 63,309,400.00 | Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага | Хандив |
| Нийт хөрөнгийн дүн | | | | | | | | | 63,309,400.00 | | |